



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 25

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ орон нутгийн өмчит хувьцаат компанийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-д тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг "Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ" орон нутгийн өмчит хувьцаат компанийн захирал Д.Бүүвэйбаатарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /В.Жавзмаа/ нарт даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



2018 07 17



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 25

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ орон нутгийн өмчит хувьцаат компанийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-д тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг "Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ" орон нутгийн өмчит хувьцаат компанийн захирал Д.Бүүвэйбаатарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /В.Жавзмаа/ нарт даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



10057



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭРДЭНЭТ-УС дулаан түгээх сүлжээ орон нутгийн  
өмчит хувьцаат компанийн 2017 оны үйл  
ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын  
тайлан



Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан дүгнүүлж ажилласан боловч хэлтэс, албад ажлын уялдаа холбоогүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалтгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаагүй, зардал хэтэрч, авлага өр төлбөр өссөн байна.

Орхон аймаг  
2018 он



Агуулга

Аудитын  
тайланг  
бэлтгэсэн:

Орхон аймаг  
дахь Төрийн  
аудитын газар

Дарга,  
тэргүүлэх  
аудитор :

Ц.Нармандах

Аудитын  
менежер:

Б.Эрдэнэ

Ахлах  
аудитор

В.Жавзмаа

Аудитор

Гэрээт ажилтан

Б.Бямбатогтох

3.Энх-Амгалан

2018 оны 07  
дугаар сар

Аудитын  
тайлантай  
холбоотой  
асуудлаар нэмж,  
тодруулах, лавлах  
зүйл байвал  
70359826,  
70350757  
дугаарын утас,  
70359826  
дугаарын факсаар  
харилцана уу.

Аудитын тайланг  
ҮАГ-ын веб  
сайтаас үзнэ үү.  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Орхон аймаг  
дахь Төрийн  
аудитын газар

Баян-Өндөр сум,  
Хүрэнбулаг баг,  
Нутгийн  
удирдлагын ордон

Товчилсон үгсийн тайлбар .....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....	3
<b>Бүлэг I. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий боловч хэлтэс албадын ажлын уялдаагүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж чадаагүй байна.</b>	
1.1 Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлүүдийг хууль эрхийн актын хүрээнд хэрэгжүүлсэн байна. ....	6
1.2 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж дүгнүүлсэн байна.....	7
1.3 Компанийн хэлтэс, албад ажлын уялдаа холбоогүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалтгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж чадаагүй байна.	8
<b>Бүлэг II. Үндэслэлтэй төлөвлөж, алдагдлыг бууруулан, өр авлагын зохистой харьцааг хангуулах шаардлагатай байна.</b>	
2.1 Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 302,663.4 мянган төгрөгөөр давж биелсэн байна. ....	10
2.2 Бодитой тооцоо судалгаагүйгээр төлөвлөснөөс зардал хэтэрсэн байна.....	11
2.3. Өр, авлагыг бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, усны объёмын авлага, өр төлбөрийг шийдвэрлүүлэх шаардлагатай байна..	13
<b>Бүлэг III. Худалдан авах ажиллагааг хууль, журмыг дагуу үр ашигтай байхаар төлөвлөж, зохион байгуулаагүй байна.</b>	
3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....	14
3.2. Хөрөнгийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ашиглах шаардлагатай байна. ....	15
3.3. Хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаж, тооллого тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. ....	16
Дүгнэлт .....	17
Зөвлөмж .....	17
Тайлангийн төсөлд ирүүлсэн санал .....	19
Тайлан баталгаажуулсан тушаал.....	20



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>УИХ</b>	<b>Улсын Их Хурал</b>
<b>ҮАГ</b>	<b>Үндэсний Аудитын газар</b>
<b>АДБОУС</b>	<b>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</b>
<b>ИТХ</b>	<b>Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>
<b>ДТС</b>	<b>Дулаан түгээх сүлжээ</b>
<b>ОНӨХК</b>	<b>Орон нутгийн өмчит хувьцаат компани</b>
<b>ХХК</b>	<b>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b>
<b>МХЕГ</b>	<b>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар</b>
<b>НДШ</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>
<b>ХХОАТ</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>
<b>ББӨ</b>	<b>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>
<b>ЦДҮС ТӨХК</b>	<b>Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компани</b>
<b>ЭХЗХ</b>	<b>Эрчим хүчний зохицуулах хороо</b>
<b>ЭДЦС ТӨХК</b>	<b>Эрдэнэтийн дулааны цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компани</b>



## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл**

### **Аудит хийх үндэслэл**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### **Аудитын зорилт, хамрах хүрээ**

Орхон аймгийн “Эрдэнэт-Ус” ДТС ОНӨХК-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- “Эрдэнэт-Ус” ДТС ОНӨХК-ийн үйл ажиллагаа холбогдох хууль, эрх зүйн хүрээнд үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх;
- “Эрдэнэт-Ус” ДТС ОНӨХК-ийн орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөж, ашигтай ажиллаж байгаа эсэх;
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлттэй, үр ашигтай байгаа эсэх.

Аудитыг “Эрдэнэт-Ус” ДТС ОНӨХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, баримт материалыг хамруулан шалгав.

### **Аудитын арга зүй**

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 300, 3000-3100/-ийг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

“Эрдэнэт Ус” ДТС ОНӨХК-тай холбоотой хууль, эрхийн актыг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, төрөл бүрийн судалгаа, тайлан зэрэг баримт, мэдээлэлд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу газар дээр нь очиж биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;





- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж зэрэг эрхийн акт, стандарт.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох, гэрээт ажилтан З.Энх-Амгалан нар 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.



## Үндсэн мэдээлэл

"Эрдэнэт-Ус дулаан түгээж сүлжээ" ОНӨХК нь Орхон аймгийн орон нутгийн өмчийн ус суваг, цахилгаан, дулаан түгээх сүлжээний барилга байгууламж, тоног төхөөрөмж бүхий эд хөрөнгийг эзэмшиж, хүн ам болон аж ахуйн нэгжийг цэвэр ус, цахилгаан, дулаанаар хангах, бохир усыг татан зайлуулах зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

1989 оноос Эрдэнэт хотын орон сууц нийтийн аж ахуйн газар, 1999 оноос "Эрдэнэт-Ус дулаан түгээж сүлжээ" ОНӨХК болон зохион байгуулагдан ажиллаж байгаа.

Нийтийн аж ахуйн үйлдвэрлэлийн ажил үйлчилгээ эрхлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд бие даасан аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг. Дулаан түгээх сүлжээний алба, ус сувгийн алба, зөөврийн усан хангамжийн алба, лифтний хэсэг гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар 320 ажиллагсад ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар дулаан түгээх сүлжээний 17.9 км шугам, ус сувгийн 47.9 км шугам, цэвэр усны гүний 9 эх үүсвэр, цэвэр усны  $2 \times 1000 \text{ м}^3$  болон  $10 \times 50 \text{ м}^3$  резерваурууд, хоногт  $400 \text{ м}^3$  бохир ус цэвэрлэх байгууламж,  $16 \text{ м}^3/\text{цаг}$ -ийн хүчин чадалтай бохир ус татан зайлуулах станц, дулаан хуваарилах 14 төв, нийтийн халуун ус, 9 давхар байрны 10 лифт зэрэг инженерийн байгууламжууд ашиглагдаж байна.

"Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бүүвэйбаатар 2016 оноос, ерөнхий нягтлан бодогчоор Е.Чулуунбат 1999 оноос хойш ажиллаж байна.





**Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий БҮЛЭГ 1. боловч хэлтэс албадын ажлын уялдаагүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж чадаагүй байна.**

**1.1 Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлүүдийг хууль эрхийн актын хүрээнд хэрэгжүүлсэн байна.**

Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 107 дугаар тогтоолын 1-р хавсралтаар “Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” орон нутгийн өмчит компанийн дүрмийг баталжээ. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн дагуу эрх бүхий байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулжээ. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон байгууллага, хүчинтэй хугацаагаар харуулбал:

Хүснэгт 1

д/д	дугаар	эхлэх огноо	хүчинтэй хугацаа	ажил үйлчилгээний төрөл	заалт	Олгосон байгууллага
1	12/2011	2016.08.29	5 жил	Дулаан түгээх	Эрчим хүчний тухай хуулийн 16-р зүйл	Эрчим хүчний зохицуулах хороо
2	13/2011	2016.08.29	5 жил	Дулаанаар зохицуулалттай хангах	Эрчим хүчний тухай хуулийн 17-р зүйл	
3	68/2013	2013.11.08	5 жил	Цахилгаанаар зохицуулалттай хангах	Эрчим хүчний тухай хуулийн 17-р зүйл	
4	67/2013	2013.11.08	5 жил	Цахилгаан түгээх	Эрчим хүчний тухай хуулийн 16-р зүйл	
5	ӨБ35-1224/15	2015.10.19	3 жил	Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх, замын угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ	Өргөк байгууламжийн 4.1 заалт	Барилга, хот байгуулалтын яам
9	339/16	2016.02.08	3 жил	0.4-15 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ	03.2.2	Эрчим хүчний яам
10	339/16	2016.02.08	3 жил	0.7-16.0 кВ/см <sup>2</sup> даралттай зуухны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ	03.3.1	
11	339/16	2016.02.08	3 жил	0.7-16.0 кВ/см <sup>2</sup> даралттай даралтат савны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ	03.4.1	
12	339/16	2016.02.08	3 жил	0.7-16.0 кВ/см <sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ	03.5.1	
13	00181	2016.05.24	3 жил	Хот суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12-р зүйл 12.2.1	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
14	00181	2016.05.24	3 жил	Ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.2	
15	00181	2016.05.24	3 жил	Цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ	12.2.3	
16	00181	2016.05.24	3 жил	Цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ	12.2.4	
17	00181	2016.05.24	3 жил	Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.5	
18	00181	2016.05.24	3 жил	Ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.6	
19	00181	2016.05.24	3 жил	Бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.7	
20	00181	2016.05.24	3 жил	Бохир усны цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.8	
21	00181	2016.05.24	3 жил	Бохир усны татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.9	
22	00181	2016.05.24	3 жил	Бохир усны цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.10	
23	00181	2016.05.24	3 жил	Хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ	12.2.12	
24	00181	2016.05.24	3 жил	Зөөврийн ус хангамжийн үйлчилгээ	12.2.13	
25	00181	2016.05.24	3 жил	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ	12.2.14	
6	145	2016.02.05	5 жил	Халуун хүйтэн усны тоолуур худалдах, суурилуулах, засварлах		Стандартчилал, хэмжил зүйн газар
7	271	2016.02.05	5 жил	Цахилгаан эрчим хүчний тоолуур худалдах, суурилуулах, засварлах		
8	57	2016.02.05	5 жил	Дулааны эрчим хүчний иж бүрдэл тоолуур худалдах суурилуулах, хүчилтөрөгчийн болон бусад төрлийн манометр, даралт хувиргагчийг засварлах		



Компанийн дүрмийн 3.1.3-т “Хэрэглэгчийн хэрэглээний цэвэр усны алдагдлыг бууруулах, цэвэр усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээ хийх” ажил үйлчилгээ эрхлэхээр тусгасан байтал уг ажил үйлчилгээг эрхлээгүй байна. Компанийн санхүүгийн байдлаас шалтгаалан лабораторийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох яам, агентлаг, орон нутгийн удирдлагад хандсан бөгөөд шийдвэрлэгдээгүй байна.

Улсын бүртгэлийн гэрчилгээнд барилга угсралтын ажил үйлчилгээ эрхлэхээр бүртгэгдсэн байтал энэхүү тусгай зөвшөөрлийн хугацаа 2017 оны 07 сарын 09-нд дуусч, 5 жилийн хугацаатай сунгагдсан байна.

## **1.2 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж дүгнүүлсэн байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх” эрхтэй гэж заажээ.

Орхон аймгийн ИТХ-аас 2017 онд орон нутгийн өмчийн бодлогын хэрэгжилтийн талаар хэлэлцсэн байна.

Тус компанийн ТУЗ-ийг аймгийн ИТХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолоор дарга, 8 гишүүнтэйгээр баталжээ.

ТУЗ-ийн хурлыг компанийн дүрэмд “Компанийн тухай хууль”-ийн 9 дүгээр бүлгийн 79 дүгээр зүйлд заасны дагуу, Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 03 сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д улирал бүр хуралдуулна гэжээ.

Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ нь 2017 онд 2 удаа хуралдаж ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, аудитын хороо болон цалин урамшууллын хорооны журмууд хэлэлцэх, 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2017 оны бизнес төлөвлөгөө батлах, бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, хөрөнгө оруулалт батлах зэрэг асуудлыг хэлэлцэж 15 тогтоол гаргасан байна. Харин 2018 оны 1-р улиралд хуралдаж, 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2018 оны бизнес төлөвлөгөө батлах, бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, хөрөнгө оруулалт батлах, 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөө баталжээ.

Тус компанийн захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу аймгийн Засаг даргатай хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан байна. Хөлсөөр ажиллах гэрээг 94 хувьтай буюу сайн ажилласан гэж дүгнэж, гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна.



Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсэн асуудлын шийдвэр, хэрэгжилтийг тухай бүр ирүүлэх
- Ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн гэрээнд удирдлагын үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлэх заалт оруулах
- Усны алдагдлыг бууруулах тал дээр судалгаа шинжилгээ хийх
- Газар доорх инженерийн шугам сүлжээнээс аймаг болон компанийн хариуцсан ялгааг харуулсан заагийн схем зураг гаргах
- Гэрэлтүүлгийн асаалтын зардлыг бууруулах эдийн засгийн тооцооллыг үндэслэлтэй хийх
- Аймгийн Засаг дарга болон бусад хэлтэс албадаас өгч буй үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь эргэж мэдээлж байх

### **1.3 Компанийн хэлтэс, албад ажлын уялдаа холбоогүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалтгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж чадаагүй байна.**

2017 онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна. Бусад байгууллагаас үндсэн ажиллагаатай холбоотой 2 удаагийн хяналт шалгалт хийгдэж, 1 албан шаардлага, 10 зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хүргүүлсэн байна. Тухайлбал:

1. МХЕГ-ын 2017 оны 4 дүгээр сард нэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлын чиглэлээр нийт 34 төрлийн зөрчлийг арилгуулахаар 07/101/49 тоот албан шаардлагыг өгчээ. Үүнээс 31 зөрчлийг арилгаж, 1 зөрчлийг бүрэн арилгаагүй, 2 зөрчил тухайн байгууллагад хамаарахгүй асуудал байна.
2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас 2016-2017 онд 10 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 5 зөвлөмж 35-50 хувийн хэрэгжилттэй байна.

2017 онд тус компанийн дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан 3 удаа өөрчлөгдсөн байна.

Компанийн дүрэмд заасны дагуу дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтныг ТУЗ-тэй зөвшилцөн 9 дүгээр сараас томилон ажиллуулжээ. 2017 оны 9 сараас эхлэн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргаж хэвшсэн бөгөөд тэдгээрийг аудитад хамруулсан болно.

Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан 2017 оны 09-12 сард байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн актуудтай танилцаж, үйл ажиллагааны чиглэлд хяналт хэрэгжүүлж, дүгнэлт санал, зөвлөмжийг холбогдох хэлтэс, албадад өгсөн хэдий ч биелэлтийг гаргаж, үнэлээгүй байна.



Тухайлбал:

- Ажлын гүйцэтгэл, хариуцлага, сахилга дэг журамд хяналтыг 2017 оны 09 сарын 27ноос 10 сарын 6-нд хэрэгжүүлж, холбогдох зөвлөмжийг өгч, алдааг арилгуулжээ.
- Тус байгууллагад ирсэн дуудлага, гомдлын дагуу ажиллаж шалгахад дуудлагаар ажилласан ажилтнууд ажлаа чанартай гүйцэтгээгүй, дахин дуудлага өгөгдсөн байна.
- Борлуулалтын байцаагчид ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэдэггүйгээс шалгалтаар 58 зөрчил илэрсэн байна.

Тус компанийн хэлтэс, албад ажлын уялдаа холбоогүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалтгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж чадаагүй байна.

Цаашид ажилтан бүрийн ажлын үр дүнг бодитой, үнэн зөв үнэлж, сахилга хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

## **БҮЛЭГ 2. Үндэслэлтэй төлөвлөж, алдагдлыг бууруулан, өр авлагын зохистой харьцааг хангуулах шаардлагатай байна.**

Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 10, 14 дугаар тогтоолоор тайлант оны төлөвлөгөөг 14,380,209.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 15,036,197.4 мянган төгрөг зарцуулан, 655,987.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталжээ.

Тайлант онд нийт 14,682,873.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 15,417,466.9 мянган төгрөгийг зарцуулан 734,593.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Төлөвлөгөөнөөс орлого 2.1 хувиар давж биелэн, зарлага 2.5 хувиар хэтэрч, алдагдал 78,606.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн 2017 оны санхүүгийн үндсэн үзүүлэлт

Хүснэгт 2

мян.төг

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017 оны хүрсэн түвшин			
			Төлөвлөгө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт орлого	мян төг	14,380,209.6	14,682,873.0	102.1	302,663.4
2	Нийт зардал	мян төг	15,036,197.4	15,417,466.9	102.5	381,269.5
3	Ашиг алдагдал	мян төг	(655,987.8)	(734,593.9)	112.1	(78,606.1)
4	Нийт ажиллагсадын тоо	хүн	323	324	100.3	1
5	Дундаж цалин	төг	795,503.0	802,490.0	100.9	6,987.0



Компанийн 2017 оны орлого, зардал, ашиг алдагдлыг салбараар харуулбал:

Хүснэгт 3

мян.төг

№	Зардал ТЗ-ийн төрлөөр	Орлого		Зардал		Ашиг, алдагдал	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Дулаан	5,810,083.00	5,872,176.30	5,855,377.30	5,931,174.70	(45,294.30)	(58,998.40)
2	Цахилгаан	3,902,069.00	3,997,093.90	3,770,245.50	3,974,420.50	131,823.50	22,673.40
3	Цэвэр ус	2,435,714.40	2,402,265.80	2,290,837.90	2,290,326.40	144,876.50	111,939.40
4	Бохир ус	1,304,564.90	1,388,223.10	1,577,468.00	1,550,757.80	(272,903.10)	(162,534.70)
5	Өөрийн эх үүсвэрийн ус	385,719.70	429,025.90	861,483.50	887,756.90	(475,763.80)	(458,731.00)
6	Цахилгаан шат	107,179.50	82,132.40	110,437.80	96,045.20	(3,258.30)	(13,912.80)
7	Тоолуур	53,129.10	44,307.30	151,279.40	147,573.20	(98,150.30)	(103,265.90)
8	Бусад	109,200.00	130,274.40	261,848.10	259,979.80	(152,648.10)	(129,705.40)
9	Хөрөнгө оруулалт		81,554.40		75,680.10	-	5,874.30
10	Нийтийн халуун ус	8,050.00	7,087.40	24,228.90	24,351.30	(16,178.90)	(17,263.90)
11	Алданги	264,500.00	248,732.20	132,991.00	179,401.10	131,509.00	69,331.10
	ДҮН:	14,380,209.60	14,682,873.10	15,036,197.40	15,417,467.00	(655,987.80)	(734,593.90)

**2.1 Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 302,663.4 мянган төгрөгөөр давж биелсэн байна.**

Тайлант онд нийт 14,682,873.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөнөөс орлого 2.1 хувиар давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр харуулбал:

Хүснэгт 3

мян.төг

№	Борлуулалтын орлогын ангилал, нэр төрөл	2016 оны гүйцэтгэл	2017 он		Зөрүү /өсөлт +, бууралт -/	
			төлөвлөгөө	гүйцэтгэл	2016 оноос	төлөвлөгөөнөөс
1	Дулаан	5,754,128.30	5,810,083.00	5,872,176.30	118,048.00	62,093.30
2	Цахилгаан	3,783,272.40	3,902,069.00	3,997,093.90	213,821.50	95,024.90
3	Цэвэр ус	2,259,412.90	2,435,714.40	2,402,265.80	142,852.90	-33,448.60
4	Бохир ус	1,222,343.70	1,304,564.90	1,388,223.10	165,879.40	83,658.20
5	Өөрийн эх үүсвэрийн ус	536,312.50	385,719.70	429,025.90	-107,286.60	43,306.20
6	Цахилгаан шат	78,977.80	107,179.50	82,132.40	3,154.60	-25,047.10
7	Бусад орлого	222,802.50	170,379.10	263,223.40	40,420.90	92,844.30
8	Алдангийн орлого	274,328.50	264,500.00	248,732.20	-25,596.30	-15,767.80
	ДҮН:	14,131,578.60	14,380,209.60	14,682,873.00	551,294.40	302,663.40

Орлогын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөнөөс 3.0 хувиар, өмнөх оны гүйцэтгэлээс 1.8 хувиар нэмэгдүүлсэн байна. Зарим орлогыг бууруулан төлөвлөсөн шалтгааныг тодруулбал:

- Алдангийн орлогыг өмнөх төлөвлөлттэй уялдуулан төлөвлөсөн байна.
- Өөрийн эх үүсвэрийн усан хангамжийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.10 дахь заалт, Засгийн газрын "Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай" 2012 оны 209 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийн дэмжлэг 2017 онд батлагдаагүйгээс шалтгаалжээ.





Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелсэн хэдий ч цэвэр ус, тоолуур, цахилгаан шат, нийтийн халуун усны орлогын төлөвлөгөө 957.7 – 33,448.6 мянган төгрөгөөр тасарчээ. Төлөвлөгөө тасарсан нь дараах асуудлаас шалтгаажээ. Үүнд:

- Цэвэр ус: Эрдэнэт хивс ХХК болон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны сул зогсолтоос шалтгаалсан байна.
- Тоолуур: 5-8 жилийн хугацаанд үечлэлтэйгээр баталгаажуулалт хийдэг бөгөөд төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй байна.
- Цахилгаан шат: Үйлчилгээний цагийг уртасгаж, төлбөрийн хэмжээг 10000 төгрөгөөр тогтоох хүсэлтийг аймгийн ИТХ-д хүргүүлсэн бөгөөд батлагдаагүйн улмаас хуучин төлбөрийн хэмжээг мөрдсөн байна.
- Нийтийн халуун ус: Барилга байгууламж хуучирч, засвар хийгдээгүйн улмаас хаагдсан байна.
- Алданги: Өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөснөөс шалтгаалсан байна.

## 2.2 Бодитой тооцоо судалгаагүйгээр төлөвлөснөөс зардал хэтэрсэн байна.

2017 онд нийт 15,036,197.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн ч 15,417,466.9 мянган төгрөгийн зардал гаргаж батлагдсан зардлын төлөвлөгөөг 381,269.5 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар хэтрүүлжээ. Зардлын гүйцэтгэлийг дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 4

мян.төг

№	Зардлын нэр төрөл	2016 он		2017 он		Зөрүү /хэтрэлт -, хэмнэлт +/	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	2016 оны гүйцэтгэлээс	2017 оны төлөвлөгөөнөөс
1	Үндсэн цалин, нэмэгдэл	2,972,789.60	2,954,648.90	3,083,371.30	3,120,080.30	165,431.40	(36,709.00)
2	НДШимтгэл	356,734.90	356,736.10	370,004.60	378,395.60	21,659.50	(8,391.00)
3	Засвар үйлчилгээ	247,677.20	239,305.40	299,667.00	262,246.00	22,940.60	37,421.00
4	Цахилгаан	525,641.50	454,392.90	494,835.30	563,439.10	109,046.20	(68,603.80)
5	Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,423,382.20	969,306.80	1,115,051.50	1,124,585.00	155,278.20	(9,533.50)
6	Түлш шатахуун	120,820.30	125,713.70	132,032.90	133,740.50	8,026.80	(1,707.60)
7	Дамжих ус, дулаан, цахилгаан	8,563,868.00	8,720,960.20	9,056,094.60	9,241,572.10	520,611.90	(185,477.50)
8	Бичиг хэрэг, холбоо	29,933.90	28,393.20	55,837.30	43,205.50	14,812.30	12,631.80
9	Хөдөлмөр хамгаалал, ариун цэвэр	115,683.50	100,086.60	134,619.80	155,432.90	55,346.30	(20,813.10)
10	Бусад зардал	399,857.90	256,667.50	294,683.10	394,769.90	138,102.40	(100,086.80)
	ДҮН	14,756,389.00	14,206,211.30	15,036,197.40	15,417,466.90	661,077.90	(381,269.50)

Зардлын төлөвлөлтийн талаар: 2017 оны зардлын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөнөөс 279,808.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Харин цахилгааны, үндсэн хөрөнгийн элэгдлийн болон бусад зардлыг нийт 444,311.7 мянган төгрөгөөр бууруулан, бусад зардлыг 724,120.1 мянган төгрөгөөр өсгөн төлөвлөжээ.

Нэмэгдүүлж төлөвлөсөн нийт зардлын 17.1% буюу 123,851.4 мянган төгрөгийг цалин, НДШ-д, 7.2 % буюу 51,989.8 мянган төгрөгийг засвар үйлчилгээний зардалд, 1.6% буюу 11,212.6 мянган төгрөгийг түлш шатахууны зардалд, 68% буюу 492,226.6 мянган төгрөгийг ББӨ-т, 3.6 % буюу 25,903.4 мянган төгрөгийг бичиг хэрэг, холбооны зардалд, 2.6% буюу 18,936.3 мянган төгрөгийг хөдөлмөр хамгааллын зардалд тус тус төлөвлөсөн байна.





Байгууллагын орон тоо 2-оор нэмэгдсэн, хөдөлмөр хамгааллын хувцас муудсан, гэрэлтүүлэг, гэнэтийн аварийн зардал болон худалдан авсан бүтээгдэхүүний өртөг өссөн зэргээс шалтгаалан зардлыг нэмэгдүүлж төлөвлөжээ. Гэхдээ засвар үйлчилгээний зардлыг төлөвлөхдөө хэлтэс албадын захиалгын дагуу төлөвлөсөн байх ба үнийн судалгаа, тооцоолол хийгээгүй, бараа материалын үлдэгдлийг тооцдоггүй байна.

Цаашид компанийн бизнес төлөвлөгөөнд шаардлагагүй хөрөнгө бэлтгэхгүй байх, орон тоо зардлыг үндэслэлгүй нэмэгдүүлэн төлөвлөхгүй байх шаардлагатай байна.

Зардлын гүйцэтгэлийн талаар:

Батлагдсан төлөвлөгөөнөөс 381,269.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан бөгөөд хэтрэлтэд дараах зардал гол нөлөөллийг үзүүлсэн байна. Үүнд:

- Орон тоо 2-оор нэмэгдэж, болзошгүй аварийн үед ажилласан техникийн үйлчилгээний ажилчдын цалин, илүү цагийн хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэргээр цалин, НДШ-ийн зардал 45,100.0 мянган төгрөгөөр хэтэрчээ.
- 8-р сараас тариф нэмэгдсэнээс цахилгааны зардал 68,603.8 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.
- Шатахууны зарцуулалтыг бүрэн хянаж, тооцоо хийдэггүйгээс шатахууны зардал төлөвлөгөөнөөс 1,707.6 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.
- Хөдөлмөр хамгааллын хувцасны эдэлгээ, чанар муудсанаас шалтгаалан 1 ажилтанд олгох нормыг өөрчилсөн, байгууллагад заавал байх нөөцөөс шалтгаалан хөдөлмөр хамгааллын зардал 20,813.1 мянган төгрөгөөр хэтэрчээ.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2,845,683.6 мянган төгрөгийн шугам, хоолой, барилга байгууламж үндсэн хөрөнгөд бүртгэсэнээс элэгдлийн зардал 9,533.5 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.
- Хэрэглэгч нэмэгдсэнээр 185,477.5 мянган төгрөгөөр худалдан авсан бүтээгдэхүүний өртөг хэтэрсэн байна.
- Гадны үйлчилгээний хөлс 2,083.1 мянган төгрөгөөр, тэтгэмж, эрчим хүчний зөвлөгөөн, тэмцээн уралдааны зардал 60,543.4 мянган төгрөгөөр тус тус хэтэрчээ.

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх онд өгсөн төлбөрийн актыг хариуцлагагүй ажилласан ажилтнаас суутгаагүй, өмнөх оны алдааг давтан гаргаж 780.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.
- Шатахуун зарцуулалтын тооцоог бүрэн хянаж, тооцоо хийдэггүй.
- Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулахгүйгээр ажил гүйлгээ бүртгэж тайлагнасан байна.
- Арилжааны банкуудад харилцах данстай боловч цалин, бараа материал худалдан авах зэрэгт 92,153.1 мянган төгрөгийг кассаас бэлнээр зарцуулсан байна.



Эдгээр зөрчлүүд нь мөнгөн хөрөнгийн хяналтгүй, үр ашиггүй зарцуулалтыг бий болгож, ажилтнуудын хариуцлагыг сулруулж байна.

Өмнөх оны аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргаж, согтууруулах ундаа худалдан авсан болон хариуцлагагүй ажилласан ажилтнаас суутгаагүй 780.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Иймд мөнгөн кассаас зарцуулах зайлшгүй үлдэгдлийг хэмжээг тогтоож, бэлэн мөнгөний зарцуулалтын хяналтыг сайжруулан, бэлэн мөнгөөрх зарцуулалтыг багасгаж, ажилтнуудын үүрэг хариуцлагыг сайжруулах шаардлагатай байх тул зөвлөмжөөр хүргүүлэв.

Компанийн ТУЗ-ийн дарга, нарийн бичиг, 7 гишүүний цалингийн зардалд 2017 онд 3,600.0 мянган төгрөг зарцуулжээ. Цалинг олгохдоо ХХОАТ-ыг суутгахгүйгээр олгосон байна. 360.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгахгүй олгосон байх тул төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

### **2.3. Өр, авлагыг бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, усны объёмын авлага, өр төлбөрийг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.**

Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК нь 2017 онд нийт 5,846,143.6 мянган төгрөгийн авлага, 9,359,516.3 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна. Өмнөх оны үлдэгдэлтэй харьцуулахад авлага 2,074,505.8 мянган төгрөгөөр, өр төлбөр 2,256,869.4 мянган төгрөгөөр өссөн байна.

#### **Авлагын талаар:**

Авлагыг өмнөх оны үлдэгдэлтэй харьцуулахад усны объёмын зөрүүгийн авлага нэмэгдсэнээс шалтгаалан 2 дахин өссөн байна. 2017 оны жилийн эцсийн авлагыг насжилтаар нь авч үзвэл 8.7 хувь нь хугацаандаа төлөгдөх, 91.3 хувь нь хугацаандаа төлөгдөөгүй авлага байна.

Авлагыг бүтцээр нь авч үзэхэд нийт авлагын 96.17 хувийг байгууллагаас авах авлага, 1.8 хувийг айл өрхөөс авах авлага, 0,03 хувийг ажилчдаас авах авлага, 0.2 хувийг НӨАТ, ААНОАТ-ын авлага тус тус эзэлж байна. Үүнээс усны объёмын зөрүүгийн авлага 3,616,799.4 мянган төгрөг нь нийт авлагын 61.9 хувийг эзэлж байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5		мян.төг	
д/д	Авлагын дансны төрөл	Дүн мян.төг	Хувь %
1	Байгууллагаас авах авлага	4,130,215.80	70.6
2	Айл өрхөөс авах авлага	104,083.70	1.8
3	Ажилчдаас авах авлага	1,625.00	0.02
4	Татварын авлага	13,667.70	0.2
5	Урьдчилан тооцсон авлага	1,596,551.40	27.3
<b>Нийт авлагын дүн</b>		<b>5,846,143.60</b>	<b>100</b>



Ажилтнуудад урьдчилгаа цалин, томилолт, шатахууны тооцоо олгож, тухай бүр тооцоо бодож хаадаггүйгээс 1,625.0 мянган төгрөгийн авлага бүрэн барагдуулаагүй байна.

Эрдэнэт үйлдвэр ХХК, ЦДҮС ТӨХК, ЭДЦС ТӨХК, ЭХЗХ зэрэг томоохон харилцагчийн тооцооны үлдэгдлийн баталгааг аудитын явцад ирүүлсэн бөгөөд борлуулалтын байцаагч нар харилцагчидтай тооцоо нийлж, тооцооны үлдэгдлийн баталгааг гаргуулж хэвшсэн байна.

### Өр төлбөрийн талаар:

2017 оны жилийн эцсийн богино хугацаат өглөгийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин буюу 2,256,869.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6	Мян.төг	
Үзүүлэлт	2017 он	Хувь %
Байгууллагад төлөх өглөг	4,340,012.20	86.4
Ажилчид, хувь хүнд өгөх өглөг	26,897.70	0.5
Татварын өглөг	117,757.00	2.3
Урьдчилж тооцсон орлого	538,373.20	10.7
Нийт дүн	<b>5,023,040.10</b>	<b>100</b>

Тайлант хугацааны татварын өглөг өмнөх үеэс 112,978.8 мянган төгрөгөөр, ажилчид хувь хүнд өгөх өглөг 7,591.8 мянган төгрөгөөр, байгууллагад өгөх өглөг 2,124,924.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Өр төлбөр 1.8 дахин өссөн нь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн усны өглөгөөс шалтгаалсан байна.

Эрдэнэт Ус ДТС ОНӨХК нь өр, авлагыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч усны объёмын авлага, өр төлбөрийг бууруулахад орон нутгийн удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Цаашид өр авлага бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай авлагыг шилжүүлэх, айл өрхөөс авах борлуулалтын авлагыг бууруулах, бусад байгууллага, хувь хүн, ажиллагсдаас авах авлагыг нэн тэргүүнд барагдуулах зэргээр тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллах нь зүйтэй юм.

### **БҮЛЭГ 3. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу үр ашигтай байхаар төлөвлөж, зохион байгуулаагүй байна.**

#### **3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.**

Эрдэнэт Ус ДТС ОНӨХК нь 1,162.520.7 мянган төгрөгийн худалдан авалтаас 9 төрлийн 300,143.5 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.

Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа хэлтэс, албадын бизнес төлөвлөгөөнд тусгасан жагсаалтын дагуу багцлаагүй байна.



Харин 862,377.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулж, шууд худалдан авсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 68-р тогтоолоор баталсан босго үнээс давсан 154,747.6 мянган төгрөгийн шатах тослох материал, 24,200.0 мянган төгрөгийн замын гэрлийн тэжээлийн блок худалдан авалтад холбогдох хууль, журмыг мөрдөөгүй байна.

Цаашид сэлбэг материал, урсгал засварын материалыг үйл ажиллагааны чиглэлийн дагуу багцлан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зардлыг бууруулах шаардлагатай байна.

### **3.2. Хөрөнгийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ашиглах шаардлагатай байна.**

Компанийн бизнес төлөвлөгөөнд хэлтэс, албад шаардлагатай үндсэн хөрөнгө, сэлбэг материалын жагсаалт, тооцоог гарган өгч нэгтгүүлдэг бөгөөд тэдгээрийг нэгтгэсэн хэлтэс материалын үнэ, байгууллагын нөөц зэргийг хянаж тооцоолохгүйгээр нэгтгэсэн байна.

Эрдэнэт Ус ДТС ОНӨХК нь 2017 онд 778,860.7 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч, 800,120.8 мянган төгрөгийн материалыг зарцуулж 464,246.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бол 2,845,683.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орон нутгийн хөрөнгө оруулалтаас нэмэгдэж, 383,660.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 101,959.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

#### Хүснэгт 7

Үзүүлэлтүүд	Үндсэн хөрөнгө /мян.төг/		Бараа материал /мян.төг/	
	2016 он	2017 он	2016 он	2017 он
Эхний үлдэгдэл	51,027,092.20	48,122,280.10	396,355.80	485,506.60
Нэмэгдсэн	3967,620.50	3,229,343.60	844,207.9	778,860.80
Хасагдсан	6,862,432.60	101,959.00	755,056.9	800,120.80
Эцсийн үлдэгдэл	48,122,280.10	51,249,664.70	485,506.8	464,246.60

Бараа материалын тайлан, анхан шатны баримтын тулган баталгаажуулахад анхан шатны баримтаар бүрэн дэмжигдэхгүй 1,905.6 мянган төгрөгийн ахуйн хэрэглээний бараа худалдан авсан байна. Иймд анхан шатны баримтаар дэмжигдээгүй 1,905.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

ТУЗ-ийн шийдвэргүйгээр 9,538.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байх тул алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Тус компанийн хөрөнгүүд хуучирч, шугам хоолойн их засваруудад их засварын шинэчлэл хийгдээгүй тул холбогдох яам, агентлаг, эрх бүхий албан тушаалтанд хандаж байгаа боловч шийдвэрлэгдээгүй байна. Энэхүү байдлаас шалтгаалан өөрийн эх үүсвэрийн хүрээнд багахан урсгал засварууд хийхээр төлөвлөж, гүйцэтгэж иржээ.



Цаашид хөрөнгийн хэрэгцээ шаардлага, байгууллагын нөөц, үнийн судалгаанд үндэслэн төлөвлөж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж ажил гүйлгээ бүртгэх, тооцооны нягтлан бодогчдын хариуцлагыг сайжруулах, ажлын үр дүнг үнэлэх, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### **3.3. Хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаж, тооллого тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.**

Эдэнэт Ус ДТС ОНӨХК 2017 онд орон нутгийн төсвөөс 2,845,683.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, өөрийн хөрөнгөөр 383,660.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бүртгэж тайлагнасан байна. Харин 101,959.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгийг хөрөнгөд бүртгэж хүлээн авсан акт үйлдэж, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан хүлээн авч ажилласан бөгөөд тухай бүр компанийн захирлын тушаалаар албаны дарга нарт картаар хүлээлгэн өгсөн байна.

Байгууллагын нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллогыг захирлын 2018 оны А/110 дугаар тушаалаар үндсэн хөрөнгийн тооллогын комиссыг 12 хүний бүрэлдэхүүнтэй, А/92 дугаар тушаалаар эргэлтийн хөрөнгийн тоолоогын комиссыг 8 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилж, тооллогын комиссууд тогтоосон хугацаанд хөрөнгө, материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулсан байна.

Тооллогоор нийт 51,249,664.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоолсноос 34,140,346.9 мянган төгрөгийн барилга байгууламж, 8,460,667.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,545,076.8 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 394,956.1 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 6,535,403.1 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгө, 173,214.1 мянган төгрөгийн программ хангамжийн үлдэгдэлтэй байна.

Хөрөнгө актлахдаа аймгийн Засаг даргын захирамжаар акталсан байна.

Харин 2017 онд худалдан авсан гаражийн газар ашиглах гэрчилгээг компанийн эзэмшилд бус жолоочийн эзэмшилд бүртгүүлсэн байна. Иймд компанийн эзэмшилд шилжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг 2018 оны эхний хагас жилийн байдлаар тулгахад 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 2018 оны 1-р сар, 04-р саруудад хугацаа хоцороож мэдээлсэн.
- Нийтийн албанд нийтийн ашиг сонирхолын зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлийг 2018 оны 03-р сард хугацаа хоцроосон.



- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлийг 2018 оны 03-р сард хугацаа хоцроосон.
- Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 2018 оны 03-р сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнд нийт 4,929,177.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 2,686.4 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 4,747,543.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 178,947.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### ДҮГНЭЛТ

“Эрдэнэт Ус” ДТС ОНӨХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

#### ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан дүгнүүлж ажилласан боловч хэлтэс, албад ажлын уялдаа холбоогүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалтгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилаагүй, зардал хэтэрч, авлага өр төлбөр өссөн байна.

- ✓ Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлүүдийг хууль эрхийн актын хүрээнд хэрэгжүүлсэн байна.
- ✓ Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж дүгнүүлсэн байна.
- ✓ Компанийн хэлтэс, албад ажлын уялдаа холбоогүй байдал, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалан дотоод хяналт шалтгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж чадаагүй байна.
- ✓ Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 302,663.4 мянган төгрөгөөр давж биелсэн байна.
- ✓ Бодитой тооцоо судалгаагүйгээр төлөвлөснөөс зардал хэтэрсэн байна.
- ✓ Өр, авлагыг бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, усны объёмын авлага, өр төлбөрийг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
- ✓ Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- ✓ Хөрөнгийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ашиглах шаардлагатай байна.
- ✓ Хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаж, тооллого тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.

### ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

#### Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бүүвэйбаатарт

- Ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг бодитой, үнэн зөв үнэлж, сахилга хариуцлагыг сайжруулах





- Мөнгөн кассаас зарцуулах зайлшгүй үлдэгдлийг хэмжээг тогтоож, бэлэн мөнгөний зарцуулалтын хяналтыг сайжруулан, бэлэн мөнгөөрх зарцуулалтыг багасгах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж, ажил гүйлгээ бүртгэх
- Байгууллагын бизнес төлөвлөгөөг бодитой тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, батлуулан, зорилтот түвшинг хангаж ажиллах.
- Байгууллагын хөрөнгө нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж байх.
- Дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, хяналт шалгалтын мөрөөр ажлын төлөвлөгөө гаргаж гүйцэтгэлийг тайлагнаж байх.
- Өр авлага бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай авлагыг шилжүүлэх, айл өрхөөс авах борлуулалтын авлагыг бууруулах, бусад байгууллага, хувь хүн, ажиллагсдаас авах авлагыг нэн тэргүүнд барагдуулах зэргээр тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллах
- Сэлбэг материал, урсгал засварын материалыг үйл ажиллагааны чиглэлийн дагуу багцлан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зардлыг бууруулах, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах.

#### **МЭДЭГДЭЛ:**

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг мэдэгдье.

#### **ТАНИЛЦСАН:**

АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

#### **ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

#### **ТАЙЛАНГ БИЧСЭН:**

АХЛАХ АУДИТОР

В.ЖАВЗМАА

АУДИТОР

Б.БЯМБАТОГТОХ



ЭРДЭНЭТ-УС дулаан түгээх сүлжээ орон нутгийн өмчит хувьцаат компанийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Мөнгөн кассаас зарцуулах зайлшгүй үлдэгдлийг хэмжээг тогтоож, бэлэн мөнгөний зарцуулалтын хяналтыг сайжруулан, бэлэн мөнгөөрх зарцуулалтыг багасгах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж, ажил гүйлгээ бүртгэх

Байгууллагын бизнес төлөвлөгөөг бодитой тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, батлуулан, зорилтот түвшинг хангаж ажиллах.

Байгууллагын хөрөнгө нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж байх.

Дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, хяналт шалгалтын мөрөөр ажлын төлөвлөгөө гаргаж гүйцэтгэлийг тайлагнаж байх.

Өр авлага бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай авлагыг шилжүүлэх, өр өрхөөс авах борлуулалтын авлагыг бууруулах, бусад байгууллага, хувьцаа ажиллагсдаас авах авлагыг нэн тэргүүнд барагдуулах зэргээр тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллах

Салбэг материал, урсгал засварын материалыг үйл ажиллагааны чиглэлийн дагуу багцлан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зардлыг бууруулах, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах.

ХЭДЭГДЭЛ:

Төлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг

ТАНИЛЦСАН:

АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

В.ЖАВЗМАА

АУДИТОР

Б.БЯМБАТОГТОХ



## ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ



### “ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ОНӨХК

61037 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Хүрэнбулаг баг, Эрх чөлөөний өргөн чөлөө  
Утас: +976-70350916, Факс: +976-70350217  
Цахим шуудан: erdenetus@gmail.com

2018.07.16 № 576

төвийг \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ОРХОН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танайхаас ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд хүргүүлэх санал байхгүй болно.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Ч.МЯГМАРСҮРЭН

G:/Documents /A-5.doc